



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 1 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар
хот


Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийг 2018 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 27.000 (хорин долоон мянган) төгрөгөөр нэмэгдүүлэн тооцож олгохыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгасугай.

2. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны бүрэн тэтгэврийн доод хэмжээг 280.000 (хоёр зуун наян мянган) төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 243.000 (хоёр зуун дөчин гурван мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 292 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

С.ЧИНЗОРИГ